



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 05 сарын 21 өдөр

Дугаар 8/98

Улаанбаатар хот

Сонгинохайрхан дүүргийн Боловсролын Хэлтсийн эргэлтийн бус хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 5,105,220.00 (таван сая нэг зуун таван мянга хоёр зуун хорин) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасан байгууллагын балансад шилжүүлж данс бүртгэлээс хасахыг Сонгинохайрхан дүүргийн Боловсролын хэлтэс (А.Дүүдээ)-д зөвшөөрсүгэй.

2.Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан хавсралтын дагуу бүртгэж авах, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Сонгинохайрхан дүүргийн Албан бус насан туршын боловсролын төвд үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ *В.Оюумаа* В.ОЮУМАА



1150590357

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 04-ны өдрийн дугаар тушаалын хавсралт

Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллага: Сонгинохайрхан дүүргийн Боловсролын хэлтэс

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Хуримтлагдсан элэгдэл- 2024 оны 04-р сарын 30- ний өдрийн байдлаар	Үлдэгдэл өртөг	Шилжүүлэх байгууллага	Шилжүүлэн авах байгууллага
1	Сурагч сандал	2019.12.31	ш	60	36,543.00	2,192,580.00	2,169,132.15	23,447.85	СХД- ийн Боловсролын хэлтэс	СХД- н Албан бус насан туршын боловсролын төв
2	Сурагч ширээ	2019.12.31	ш	30	97,088.00	2,912,640.00	2,793,184.15	119,455.85		
						5,105,220.00	4,962,316.30	142,903.70		